“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН
2023 ОНЫ 5 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.06.08

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТҮГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн 5 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

| Нэгжийн нэр | Төлөвлөсөн ажил | Үүнээс | | | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | ХБ | |
| ЗСХ | 16 | 11 | - | 2 | 2 | - | - | - | 83.75 |
| ТНУАСХ | 17 | 12 | - | 4 | - | 1 | - | - | 88.23 |
| ГХБАБМХ | 9 | 9 | - | - | - | - | - | - | 100 |
| **Дүн** | **42** | **32** | **-** | **6** | **2** | **1** | **-** | **-** | **89.04** |

**ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ А.БУЯННЭМЭХ

ТНУАСХ-ИЙН ДАРГА Д.ТӨГСЖАРГАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА Ц.ОЮУНБАТ

**БОЛОВСРУУЛСАН:**

ХШҮМ Э.Осоржамаа Э.ОСОРЖАМАА

## ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023 оны 6 дугаар сарын 06-ны өдөр

| д/д | Хийгдэх ажил | Хүрэх түвшин | Хэрэгжилт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | Зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн 2022 оны 4-р сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх **Э.Осоржамаа** | Тайланг удирдлагад танилцуулж эйбл системд байршуулж мэдээлсэн байна. | Нэгжүүдийн 4-р сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг удирдлагад 2023.05.08-ны өдөр танилцуулсан. ХШҮ-ний тайланг 2023.05.09-ний өдөр эйбл системд байршуулж мэдээлсэн. Нэгжүүдийн төлөвлөгөөний биелэлт 87.2%-ийн хэрэгжилттэй үнэлэгдсэн. | 100% |
| 2 | Ажилтнуудын 3, 4-р сарын цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтад дүн шинжилгээ хийж танилцуулах **Э.Осоржамаа** | Тайланг захиралд танилцуулсан байна. | Ажилтнуудын 3, 4-р сарын цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтад хийсэн дүн шинжилгээг захиралд 2023.05.18-ны өдөр танилцуулсан. | 100% |
| 3 | Төвийн захирлын 2021 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсэгт ажиллах **Э.Осоржамаа** | Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасан нөхцөл, шаардлагын дагуу хянан дүгнэлт гаргасан байна. | “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2023.03.01-ний өдрийн А/15 дугаар тушаалын хавсралтаар ажил мэргэжлийн жагсаалт батлагдсантай холбогдуулан “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2021.02.09-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/18 дугаар тушаалд захирлын 2023.05.03-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар өөрчлөлт орж ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн. | --- |
| 4 | Захиргаа, санхүүгийн хэлтсийн 2023 оны 5-р сарын төлөвлөгөө нэгтгэж батлуулах **Э.Осоржамаа** | Төлөвлөгөө батлагдсан байна. | Захиргаа, санхүүгийн хэлтсийн 2023 оны 5-р сарын төлөвлөгөөг нэгтгэж 2023.05.01-ний өдөр батлуулсан. | 100% |
| 5 | Төвийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартын дагуу хөтлөх **Э.Осоржамаа** | 1. Албан хэрэг хөтлөлтийг журам, стандартын дагуу хөтөлсөн байна.<br>2. Баримт бичгийн шийдвэрлэлтийн мэдээ тайлан (2023.01.03-04.28) боловсруулах, вэб сайт, RTCC-д байршуулж мэдээлсэн байна.<br>3. Шийдвэрлэх хугацаа хэтэрсэн албан бичгийн мэдээ гаргасан байна. | 1. АХХ-ийн мэргэжилтний албан үүргийг 2023.05.01-05, 2023.05.15-18-ны хугацаанд нийт 9 өдөр түр орлон гүйцэтгэж 49 хуудас 27 ирсэн бичиг, 800 хуудас, 40 хувь, 22 явсан бичиг, 3 хуудас 2 өргөдөл, 4 хуудас 2 тушаал, нийт 856 хуудас 53 баримт бичгийг АХХ-ийн журам, стандартын дагуу хөтөлсөн.<br>2. Баримт бичиг хянан шийдвэрлэсэн 4-р сарын тайлан мэдээг 2023.05.01-ний өдөр захиралд танилцуулсан. 4-р сарын байдлаар 54 албан бичиг хяналтад байгаагаас хугацаанд нь шийдвэрлэсэн 18, хугацаандаа шийдвэрлэгдэж байгаа 30, хугацааг сунгасан 4, хугацаандаа | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 4. Төвөөс явуулсан албан бичигт хариу ирээгүй болон ирсэн бичгийн судалгаа гаргасан байна. | шийдвэрлэгдээгүй 2 бичиг байна. Байгууллагын хэмжээнд 2023.01.02-2023.04.28-ны хугацаанд ирсэн хариутай албан бичиг, өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн тайланг хариу өгсөн байдал, ангилал төрөл гэсэн 2 хувилбараар боловсруулж RTCC группт 2023.05.02-ны өдөр байршуулж мэдээлэв. Төвийн хэмжээнд хариутай 188 бичиг ирснээс албан бичгээр 63, сайдын тушаалаар 69, захирлын тушаалаар 1, цахимаар 5, утсаар 1, бусад хэлбэрээр 5, хугацаа хоцроож шийдвэрлэсэн 4, хугацаа болоогүй 3, шийдвэрлэгдэх шатанд 31, хариу өгөөгүй 6, баримт бичгийн шийдвэрлэлт 78.7 хувьтай байна. Бүртгэл хяналтын 36 картыг хааж, ирсэн бичгийн хэзээ, хэрхэн шийдвэрлэсэнд тэмдэглэгээ хийв.<br>3. Шийдвэрлэх хугацаа хэтэрсэн баримт бичгийн мэдээг 2023.05.03, 2023.05.11, 2023.05.18, 2023.05.25-ны өдөр гаргасан.<br>4. Төвөөс явуулсан албан бичигт хариу ирээгүй болон ирсэн бичгийн судалгаа гаргасан. 2023.01.02-2023.05.24-ний өдрийн хугацаанд Төвөөс төмөр замын байгууллага болон бусад байгууллагад хариу ирүүлбэл зохих 79 албан бичгийг 146 хувь үйлдэж явуулснаас 34.9 хувь буюу 51 нь албан бичгээр, 6.2 хувь буюу 9 нь цахимаар хариу ирж, 11.7 хувь буюу 17 албан бичиг бусад хэлбэрээр шийдвэрлэгдэж, 30.8 хувь буюу 45 албан бичигт хариу ирээгүй, 16.4 хувь буюу 24 албан бичиг шийдвэрлэгдсэн эсэх нь тодорхойгүй байна.<br>5. ЗТХ-ийн сайдын 2023 оны А/136, А/137, А/149, А/150-р тушаалаар гэрчилгээ олгогдож, захирлын гарын үсгээр баталгаажсан 23 хуулийн этгээдийн 44 гэрчилгээг тамгалав. | |
| 6 | Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох анхдугаар зөвлөгөөний хурлын тэмдэглэлийг бичих **Э.Осоржамаа** | Анхдугаар зөвлөгөөний хурлын тэмдэглэлин аудиог 01 цаг 49 минут 33 секунтаас дуустал сонсож найруулга зүй, үг үсгийн алдааг зассан байна. | Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох анхдугаар зөвлөгөөний хурлын тэмдэглэлийн аудио 1-р хэсэг болох 3 цаг 27 минут 28 секунд, 2-р хэсгийн 3 цаг 03 минут 36 секундын бичлэгийг сонсож хэлэлцсэн асуудал, төлөөлөгч | 50% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | нарын хэлсэн саналыг нэг бүрчлэн сонсож, тулгаж, шалгаж дэс дарааллын үг үсгийн алдааг зассан. | |
| 7 | ЗТХЯ-нд хугацаатай тайлан, мэдээллийг тайлагнах **Э.Осоржамаа** | Хугацаанд нь шуурхай тайлагнасан байна. | ЗТХ-ийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2023.05.04, 2023.05.18, 2023.05.31-ний өдөр ТЗУГ-т, төвийн гүйцэтгэлийн тайланг 2023.05.05-ны өдөр, сайдын албан даалгаврын хэрэгжилтийг 2023.05.03, 2023.05.17, 2023.05.31-ний өдөр ХШҮДАГ-т цахим шуудангаар тус тус тайлагнасан. | 100% |
| 8 | Хүний нөөц, хөдөлмөрийн харилцааны асуудлыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлүүлэх **М.Оюун-Ундрам** | Хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлүүлсэн байна. | Хүний нөөц, хөдөлмөрийн харилцаатай холбогдсон үйл ажиллагааг холбогдох хууль, дүрмийн дагуу шийдвэрлүүлсэн. Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б тушаалын төсөл-4, үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой А тушаалын төсөл-3 боловсруулж батлуулсан. Ээлжийн амралтын дагуу 1 ажилтанд ээлжийн амралтыг хэсэгчлэн эдлүүлсэн. | 100% |
| 9 | Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр батлуулах **М.Оюун-Ундрам** | Хөтөлбөр боловсруулж, батлуулсан байна. | Хүний хөгжлин хөтөлбөр 2023-2027 төслийг боловсруулан төлөвлөлтөд оруулсан. Удирлагаар хянагдаад батлагдана. | 50% |
| 10 | МУ-ын Засгийн газрын авилгатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд ЗТХ-ийн сайдын 2023 оны А/80 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтаар төвд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах **М.Оюун-Ундрам** | Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, шуурхай тайлагнасан байна. | Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газраас 2023.04.26-ны өдрийн 05/1924 тоот "Зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчил арилгах" албан бичгийн дагуу шалгалтад дурдагдсан нэр бүхий 2 албан хаагчид 2023.05.02-ны өдрийн Б/17, Б/20 тушаал, 2023.05.23-ны 225 албан тоотоор сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлсэн. Шүүр ажиллагааны зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг 2023.05.25-ны 228 албан тоотоор ЗТХЯ-ны ТЗУГ-т хүргүүлсэн. | 100% |
| 11 | МУ-ын Шадар сайдын Ажлын алба, Үндсэний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой байдлын ерөнхий газар хамтран зохион айгуулах Команд штабын сургалтад төвийн ГХОБТШ-ын мэдээлэл бэлтгэн хүргүүлэх **М.Оюун-Ундрам** | Сургалтад хамрагдаж, мэдээлэл бэлтгэн хүргүүлсэн байна | Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө, Гамшгаас хамгаалах орон тооны бус комиссыг баталсан тушаал, Гамшгаас хамгаалах хүн хүч, техникийн хэрэгслийн нөөцийн судалгааг бэлтгэн munhkbulgan@mrtd.gov.mn цахим шуудангаар 05 сарын 19-ний өдөр хүргүүлсэн. | 100% |
| 12 | Ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах **М.Оюун-Ундрам** | Үзлэг зохион байгуулж, нийт ажилтныг хамруулсан байна. | Урьдчилан сэргийлэх үзлгийг 05 сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, нийт ажилтныг хамруулж байна. Үзлэгт нийт 20 ажилтан, үүнээс эрт илрүүлэгийн шинжилгээнд 6 ажилтан хамрагдаж, нэмэлт шинжилгээ хийлгэж байна. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 13 | Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган холбогдох тайлан мэдээг хуулийн хугацаанд бэлтгэн тайлагнах **С.Золзаяа** | Холбогдох тайлан мэдээллүүдийг хуулийн хугацаанд бэлтгэн баталгаажуулсан байна. | Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд төсвийн гүйцэтгэлийн мэдээг бэлтгэн харьяа төрийн санд, төрийн өмчийн хөрөнгийн статистик тайлан мэдээг ТӨБЗГ-т хүргэн баталгаажуулсан. | 100% |
| 14 | Шилэн дансны мэдээллийг бэлтгэн цахим хуудаст байршуулах **С.Золзаяа** | Хуулийн хугацаанд бэлтгэн байршуулсан байна. | - 2023.05.31-ний өдрийн байдлаар хугацаа болсон 47 мэдээллийг бэлтгэн https://info.shilendans.gov.mn/ байршуулсан. | 100% |
| 15 | Төслийн барилгын зураг төслийн ажилд шаардлагатай холбогдох мэдээллийг бэлтгэн хүргэх **С.Золзаяа** | Техникийн нөхцөл болон холбогдох газруудаас шаардлагатай тодорхойлолт мэдээллүүдийг авч өгсөн байна. | Төслийн барилгын ажлын зураг дуусч холбогдох газруудаар хянагдаж байгаа бөгөөд гадна шугам сүлжээний зурагт нэмэлтээр шаардагдсан мэдээллүүдийг авахаар холбогдох газруудтай хамтран ажиллаж байна. | 70% |
| 16 | Орон сууцны барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг гаргуулах **С.Золзаяа** | Архитектур төлөвлөлтийн даалгаврыг өөрчлүүлсэн байна. | Архитектур төлөвлөлтийн даалгаврыг өөрчлүүлэхэд тодорхой болсон барилгын зураг шаардлагатай. Барилгын давхар захиалагчдын хүсэлтээр 10 болон өөрчлөгдсөн бөгөөд зургийг 10 давхар байхаар хүчитгэл хийж тооцсоноор дахин гүйцэтгүүлж байна. | 70% |

_____o0o_____

## ТЭЭВРИЙН НЭГДСЭН УДИРДЛАГА, АВТОМАТЖУУЛАЛТ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН 4 ДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 5 дугаар сарын 01-ний өдөр

| Хийгдэх ажил | Хэмжих үзүүлэлт | Хянасан огноо | Хэрэгжилтийн байдал | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1. Нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хилийн галт тэрэг солилцоо, суурь бүтэц хоорондын галт тэрэг солилцоо, хөдөлгөөний зурмагийн тасалдал, нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын экспортын ачилт үзүүлэлтээр инфографик мэдээ бэлтгэх | 2 удаа инфографик мэдээ бэлтгэж төвийн вайбер группэд байршуулсан байна. | 2023.05.31 | **Б.Буманцэцэг** 23/05/17<br>Нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хилийн галт тэрэг солилцоо, суурь бүтэц хоорондын галт тэрэг солилцоо, хөдөлгөөний зурмагийн тасалдал, нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын экспортын ачилт үзүүлэлтээр инфографик мэдээ бэлтгэж 2023 оны 05 дугаар сарын 1, 17-ны өдрүүдэд төвийн вайбер группэд байршуулсан. | 100% |
| 2. 2023 оны 4 дүгээр сарын зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж ЗТХЯ-нд танилцуулах | 2023 оны 4 дүгээр сарын зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж ЗТХЯ-нд танилцуулсан байна. | 2023.05.31 | **Б.Буманцэцэг** 23/05/09<br>2023 оны 4 дүгээр сарын зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж 5 дугаар сарын 8-ны 199 дугаартай албан бичгээр ЗТХЯ-ны СХГ-т хүргүүлж танилцуулсан. | 100% |
| 3. Галт тэрэгний хөдөлгөөний 2022-2023 оны өвлийн нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд ашиглалтын ажлын болон тоон үзүүлэлтээр дүн шинжилгээ хийх | Нэгдсэн зурмагт дүн шинжилгээ хийж суурь бүтэц эзэмшигчдэд шинжилгээ, албан даалгаврыг хүргүүлсэн байна. | 2023.05.31 | **Б.Буманцэцэг** 23/05/19<br>Галт тэрэгний хөдөлгөөний 2022-2023 оны өвлийн нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд ашиглалтын ажлын чанарын болон тоон үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж суурь бүтэц эзэмшигч нарт ("УБТЗ" ХНН, "МТЗ" ТӨХК, "БТЕГ" ХХК, "ТТЗ" ХХК) 05 дугаар сарын 19-ний 221 дугаартай албан бичгээр гүйцэтгэлийг сайжруулах албан даалгавар хүргүүлсэн. | 100% |
| 4. Төмөр замын байгууллагын төлөөллийг оролцуулсан 2022-2023 оны өвлийн нэгдсэн | Дүнгийн хурал зохион байгуулсан байна. | 2023.05.31 | **Б.Буманцэцэг** 23/05/30<br>2022-2023 оны өвлийн нэгдсэн зурмагийн хэрэгжилтийг дүгнэх дүнгийн хурлыг 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| зурмагийн хэрэгжилтийн дүнгийн хурал зохион байгуулах | | | Дүнгийн хуралд "УБТЗ" ХНН, "МТЗ" ТӨХК, "БТЕГ" ХХК, "ТТЗ" ХХК-ийн галт тэрэгний зурмаг хариуцсан нэгжийн дарга, инженерүүд ирж оролцон нэгдсэн зурмагийн биелэлтийг дүгнэж гүйцэтгэлийг сайжруулах талаар хэлэлцэв. | |
| 5. 2.1. Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төслийг үргэлжлүүлэх | Төсөвлсөн ажлуудаа хугацаандаа хийж гүйцэтгсэн байна. | 2023.05.31 | **О.Оюунболд** 23/05/31<br><br>ГТХЗНТ-ийн барилгын зураг төслийн ажил 90 хувьтай явагдаж байна. Барилгын цахилгаан, дулааны техникийн нөхцөлийг шинэчлэхээр холбогдох газруудад хүсэлт өгөөд байна. | 70% |
| 6. 2.4. ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуультай төмөр замын мэдээллийн технологийн чиглэлээр хамтран ажиллах | Төсөвлсөн ажлуудаа хугацаандаа хийж гүйцэтгсэн байна. | 2023.05.31 | **Т.Мейрамбек** 23/05/31<br><br>1. Системийг хөдөлгөөнгүй бэхлэх, суурилуулах аргалыг тодорхойлж зориулалт бүхий кейсд тогтоож бэлэн болгосон.<br><br>2. "УБТЗ" ХНН-ийн Рашаант өртөөнөөс Толгойт өртөө чиглэлд 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр аялах ачааны галт тэрэгний баруун тэргэнцэр болон тоормосны хөшүүргэн дамжуулгад суурилуулан туршихаар цахилгаан гаргуулсан.<br><br>3. "УБТЗ" ХНН-ийн 2023.05.26-ны өдөр зохион байгуулан "Оюуны өмч-Инновац" өдөрлөгт судалгаа, туршилтын системийг оролцуулан үзэгч, сонирхогчдод системийн ажиллагаа, систем зорилго, зорилтыг танилцуулан ажилласан. | 100% |
| 7. 2.5. Галт тэрэг найруулах төлөвлөгөөг цахим хэлбэрт шилжүүлэх, сэлгээний ажлын хяналтыг автоматжуулах туршилт, судалгаа хийх ажлын хүрээнд | Төсөвлсөн ажлуудаа хугацаандаа хийж гүйцэтгсэн байна. | 2023.05.31 | **Т.Мейрамбек** 23/05/31<br>1. Туршилт хийхэд шаардлагатай төсвийг шийдэж өгөх тухай зардлыг тооцоог "Төв"-ийн нягтланд танилцуулсан.<br>2. "Төв"-ийн захирлын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр хүсэлт гаргасан, 5 дугаар сарын хуваарьт төлөвлөгөөнд тусгасан болов ч зөвлөл зохион байгуулагдаагүй.<br>3. Албан бус байдлаар туршилтын системийн танилцуулгыг "УБТЗ" ХНН-ийн зүтгүүрийн байцаагч, "МТЗ" ТӨХК-ийн зүтгүүрийн инженерүүдэд танилцуулсан. | 30% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8. Олон нийтийн сүлжээ, төвийн цахим сайт, Ган зам сонинд мэдээ, мэдээлэл болон контент бэлтгэн төвийн үйл ажиллагааг сурталчилсан байна | Мэдээ,мэдээлэл бэлтгэн төвийн цахим сайт, олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчилсан байна. | 2023.05.31 | **Д.Амарзаяа** 23/05/31<br>Төвийн цахим сайт болон олон нийтийн сүлжээнд төвийн үйл ажиллагааг сурталчилсан. Гэрчилгээжүүлэлтийн 5 сар, хөдлөх бүрэлдэхүүний 5 сар, ачаа тээврийн 4 сар, магистрын дипломоо авлаа, монгол бичгийн сургалтад хамрагдлаа, боловсролын үзэсгэлэнд оролцлоо, хөдөлгөөний аюулгүй байдлын зөвлөгөөнд оролцлоо, 2023 оны Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Welcom to mongolia дэд цэс нээн банер, лого, хуанли, олон улсын нислэгийн чиглэл, галт тэрэгний хуваарь мэдээ мэдээлэл бэлтгэн байршуулсан. Мөн Зам тээврийн салбарын viber чатад орсон нэгдсэн мэдээ мэдээллийг цаг тухай бүр олон нийтийн сүлжээнд байршуулан ажилласан. | 100% |
| 9. Төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хороог төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллээр хангах | ТЗТБ болон ҮСХ-г төмөр замын салбарын статистик мэдээллээр хангасан байна. | 2023.05.31 | **Д.Өлзийсайхан** 23/05/30<br>Төмөр замын тээврийн статистик мэдээ 2023 оны 04 дүгээр сарын мэдээг нэгтгэн боловсруулж 2023 оны 05 дугаар сарын 19-нд ҮСХ--статистикийн мэргэжилтэнд 9 мэдээ, ЗТХЯ-ны статистикийн мэргэжилтэнд 18 мэдээг цахимаар хүргүүлсэн. ЗТХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газар, ТЗДТБХЗГ-т 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 220 тоот албан бичгээр 21 хуудас 18 мэдээ хүргүүлсэн. | 100% |
| 10. Суурь бүтэц эзэмшигчдийн тээвэрлэсэн ачаа тээврийн статистик үзүүлэлтүүдийг харуулсан мэдээ бэлтгэн олон нийтэд мэдээлэх, вайберт байршуулах | Суурь бүтэц эзэмшигчдийн тээвэрлэсэн ачаа тээврийн статистик мэдээг олон нийтэд мэдээлсэн байна. | 2023.05.31 | **Д.Өлзийсайхан** 23/05/30<br>Суурь бүтэц эзэмшигчийн тээвэрлэсэн ачааны хэмжээ (импорт, экспорт, дамжин өнгөрсөн, орон нутаг-тонн), чингэлэг тээвэрлэлт (импорт, экспорт, орон нутаг, транзит-тонн), зорчигч тээвэрлэлт (олон улс, орон нутаг-хүн) 2023 оны 04 дүгээр сарын ачаа тээврийн статистик мэдээг нэгтгэн болосруулж 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр төвийн цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулж мэдээлсэн. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх | Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөнө. | 2023.05.31 | **Д.Өлзийсайхан** 23/05/30<br><br>Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн санд хоногийн 750 мэдээ, 7 хоногийн 40, сарын 60 мэдээг бүрдүүлж мэдээллийн нэгдсэн санд байршиж байна. | 100% |
| 12. Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг шинэчлэн боловсруулах талаар төмөр замуудаас санал авах | Журмыг шинэчлэн боловсруулах талаар төмөр замуудаас санал авсан байна. | 2023.05.31 | **Д.Өлзийсайхан** 23/05/30<br><br>ЗТХ-ийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаалаар баталсан “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах санал авч байгаа талаар төвийн сайтанд байршуулсан ба сууръ бүтэц эзэмшигчдэд 2023.04.05-ны өдрийн 133 тоот албан бичэг явуулж холбогдох хүмүүст нь мэдээлэл өгсөн. 2023.04.26-нд “УБТЗ” ХНН-с 22/32, 2023.05.22-нд “МТЛайн” ХХК-с 23/367, “ТТЗ” ХХК-с 2023.05.22-нд 2/889 тоот албан бичгээр санал ирсэн. | 60% |
| 13. 2.2. Төмөр замын аюулгүй байдлын хяналтын нэгдсэн систем хөгжүүлэлт /платформ/-д тавигдах ажлын ерөнхий даалгавар боловсруулах | Төсөвлөсөн ажлуудаа хугацаандаа хийж гүйцэтгэсэн байна. | 2023.05.31 | **О.Оюунболд** 23/05/31<br><br>Төмөр замын аюулгүй байдлын хяналтын нэгдсэн систем хөгжүүлэлтэд тавигдах ажлын даалгавар боловсруулан ЗТХЯ-аар батлуулахаар хүлээгдэж байна. | 70% |
| 14. ОХУ-ын Эрхүү хотын Зам харилцааны улсын их сургуулийн "Тээврийн мэдээллийн систем ба технологи" мэргэжлийн магистрын 1-р курсын 8 оюутнуудыг сургалтад хамруулах. | Сургалтад бүрэн хамруулсан байна. | 2023.05.31 | **У.Уранчимэг** 23/05/30<br><br>ОХУ-ын Эрхүү хотын Зам харилцааны улсын их сургуулийн "Тээврийн мэдээллийн систем ба технологи" мэргэжлийн магистрын 1-р курсын 8 оюутнуудыг сургалтад бүрэн хамруулсан. | 100% |
| 15. ОХУ-ын Эрхүү хотын зам харилцааны улсын их сургуулийн тээврийн | Бүртгэлийг хийсэн байна. | 2023.05.31 | У.Уранчимэг 23/05/30<br>ОХУ-ын Эрхүү хотын зам харилцааны улсын их сургуулийн тээврийн мэдээллийн систем ба технологи, тээвэр логистик, | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| мэдээллийн систем ба технологи, тээвэр логистик, програмийн инженер, тээврийн удирдлага зэрэг мэргэжлээр элсэлтийн бүртгэлийг явуулах. | | | програмийн инженер, тээврийн удирдлага зэрэг мэргэжлээр элсэлтийг явуулж одоогоор 5 хүн бүртгэл хийсэн. | |
| 16. Суурь бүтэц эзэмшигчдийн хөдөлгөөнтэй холбоотой ажилтнуудыг хамруулан галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар ЗТХЯ-ны Салбарын хяналтын алба, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Тээврийн хяналтын албатай зөвлөгөөнийг салбарын хэмжээнд хамтран зохион байгуулах. | Зөвлөгөөнийг зохион байгуулсан байна. | 2023.05.31 | **У.Уранчимэг** 23/05/30<br><br>Суурь бүтэц эзэмшигчдийн хөдөлгөөнтэй холбоотой ажилтнуудыг хамруулан галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар ЗТХЯ-ны Салбарын хяналтын алба, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Тээврийн хяналтын албатай зөвлөгөөнийг салбарын хэмжээнд 2023.05.25 өдөр Ган паласт 163 хүний ирцтэй хамтран зохион байгуулсан. | 100% |
| 17. “Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимыг ажлын хэсгийн хурлын шийдвэрийг үндэслэн батлах. | Төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимыг баталсан байна. | 2023.05.31 | **У.Уранчимэг** 23/05/30<br><br>“Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горимыг ажлын хэсгийн хурлын шийдвэрийг үндэслэн батлах ажлын явц суурь бүтэц хоорондын гэрээг хавсралтаар тусгах шаардлагатай тул талуудын гэрээний улмаас хойшлогдсон. | 70% |

**ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ, ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН АШИГЛАЛТ, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 5 дугаар сарын 04-ний өдөр

| д/д | Хийгдэх ажил | Хүрэх түвшин | Хэрэгжилтийн байдал | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгах, санал дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэхээр уламжлах, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх ажлыг хэрэгжүүлэх<br>**Н.Номин** | Хуулийн этгээдийн хүсэлтийг нягталж, ажлын хэсгийн дүгнэлтийг ЗТХЯ-нд уламжилсан байна. Мэдээллийн нэгдсэн сан үүсгэн хөтөлсөн байна. | Гэрчилгээжүүлэлттэй холбоотойгоор тайлант хугацаанд төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим обьект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх хүсэлтийг 51 аж ахуй нэгж, байгууллага ирүүлсэн.<br>Хүсэлт ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн хүсэлт дараах байдлаар шийдвэрлэгдсэн байна. Үүнд:<br>· Баримт бичгийн бүрдэл дутуу шалтгаанаар буцаагдсан – 21<br>· Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж буцаасан – 1<br>· Ажлын хэсгийн хурлаар дэмжигдсэн – 21<br>· Ажлын хэсгийн хурлаар ороход бэлэн болсон – 3<br>· Хүсэлт ирүүлсэн, одоогоор хянагдаагүй байгаа – 0<br>· Гэрчилгээ олгогдсон – 5<br><br>- Ажлын хэсгийн 2 удаа (5-р сарын 11, 29-ны өдөр)-ийн хурал хуралдсан. 2023 оны 5 дугаар сарын 11-ны өдрийн №09 тоот хурлаар нийт 20 аж ахуйн нэгжийн 80 гэрчилгээ шинээр олгох болон сунгуулах асуудлыг хэлэлцсэн. Үүнээс:<br>· Шинээр олгохоор шийдвэрлэгдсэн: 7<br>· Сунгахаар шийдвэрлэгдсэн: 6<br>· Дараагийн хурлаар шийдвэрлэхээр хойшлуулсан: 5<br>· Буцаахаар шийдвэрлэгдсэн: 2<br>Хурлын тэмдэглэлийг хөтөлж ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан, гэрчилгээг олгох 13 аж ахуйн нэгж (24ш гэрчилгээ)-ийн гэрчилгээг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А165, А166 дугаар тушаалын дагуу хэвлэх шатандаа явж байна.<br>2023 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн №10 тоот хурлаар нийт 13 аж ахуйн нэгжийн 50 гэрчилгээ шинээр олгох болон сунгуулах, хүчингүй болгох асуудлыг хэлэлцсэн. Үүнээс:<br>· Шинээр олгохоор шийдвэрлэгдсэн: 5 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | · Сунгахаар шийдвэрлэгдсэн: 5<br>· Дараагийн хурлаар шийдвэрлэхээр хойшлуулсан: 1<br>· Буцаахаар шийдвэрлэгдсэн: 1<br>· Гэрчилгээг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн: 1<br>Хурлын тэмдэглэлийг хөтөлж ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан, гэрчилгээг олгох 10 аж ахуйн нэгж (47ш гэрчилгээ)-ийг Зам, тээврийн хөгжлийн яаманд шилжүүлсэн ба хяналтын шатандаа явж байна.<br><br>Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А149, А150 дугаар тушаалын дагуу 11 аж ахуй нэгжийн 60 ширхэг гэрчилгээг /20/, 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А165, А166 дугаар тушаалын дагуу 13 аж ахуй нэгжийн 73 ширхэг гэрчилгээг /24/ хэвлэн Төвийн захирлаар баталгаажуулан авч аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн. Ажлын хэсгийн хурлаар буцаахаар шийдвэрлэсэн 5 аж ахуйн нэгжийн албан бичгийг боловсруулан батлуулсан бөгөөд “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-ээр буцаасан. Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлж хөтлөн, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.8-д заасны дагуу гэрчилгээ олгосон хуулийн этгээдүүдийн мэдээллийг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т 2023 оны 5 дугаар сарын 31 -ны өдөр тайлагнасан. | |
| 2 | Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмыг шинэчлэх боловсруулах<br>**Н.Номин** | Төмөр замын байгууллагуудаас санал авах, цахим хуудсанд 30-аас доошгүй хоног байршуулж мэдээллэн, санал авсан байна. | Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал авахаар төмөр замын суурь бүтэц эзэмшигч байгууллагууд болох “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “ТТТЗ” ХХК, “БТЕГ” ХХК, “Монголиантранс лайн” ХХК, “Монголиан транс ложистик” ХХК-нд тус тус 2023 оны 05 дугаар сарын 03-ны 190 тоот албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар “Монголиантранс лайн” ХХК болон “ТТТЗ” ХХК-аас хариу ирүүлсэн. “УБТЗ” ХНН албан бичгийн хариуг шууданд өгсөн талаар мэдэгдсэн бол бусад байгууллагууд хариу ирүүлэхээр боловсруулж байгаа талаар мэдэгдсэн.<br><br>ЗТХЯ болон ГТХЗНТөвийн цахим хуудсанд тус тус 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр журамд нэмэлт өөрчлөлт | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | оруулах санал авахаар байршуулан мэдээлсэн бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар Төвийн албан майлд ирүүлсэн санал байхгүй байна. | |
| 3 | Гэрчилгээжүүлэлтийн сарын статистик мэдээг бэлтгэн боловсруулах, ажлын хэсгийн чиг үүргийн дагуу “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-д ажиллах<br>**Н.Номин** | Гэрчилгээжүүлэлтийн сарын статистик мэдээг боловсруулж Төвд танилцуулсан байна.<br>Цахим системд чиг үүргийн дагуу ажилласан байна. | Ажлын хэсгийн чиг үүргийн дагуу иргэн аж, ахуйн нэгжийн хүсэлтийг “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-ээр хүлээн авч, хэрэгжүүлж ажиллаж байна.<br><br>Гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийн 2023 оны 5 дугаар сарын 11, 29-ны хурал хуралдахын өмнө нийт 21 байгууллагад ажлын хэсгийн гишүүд нэг бүрийн ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гаргаж, шилэн дансанд байршуулуулахаар Төвийн нягтлан бодогч С.Золзаяад тухай бүр хүлээлгэн өгсөн.<br><br>Гэрчилгээжүүлэлтийн 2023 оны 5 дугаар сарын статистик мэдээг бэлтгэн боловсруулж Төвийн удирдлага болон мэргэжилтнүүдэд танилцуулсан. | 100% |
| 4 | Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр код болон дугаар олгох, дугаарыг баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх<br>**Т.Туяа** | Хөдлөх бүрэлдэхүүний дугаарын олгож, мэдээллийн санд бүртгэсэн байна. | 2023 оны 05-р сард мэдээллийн сангаас нийт 99 ачааны вагоныг хассан. /MIRTS ХХК-ны 50 хагас вагон, Эйр катеринг ХХК-ны 48 тавцант вагон, ДЦС-4 ТӨХК-ны 1 хагас вагон вагон/. | 100% |
| 5 | Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект үйл ажиллагаанд гэрчилгээ олгох сунгах, түдгэлзүүлэх, баримт бичгийн бүрдлийг шалгах, ажлын хэсгийн хуралд оролцох<br>**З.Мөнхтуяа** | Ажлын хэсгийн хуралд оролцсон байна. | Хөдлөх бүрэлдэхүүний гэрчилээ шинээр авах “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 61 тавцант вагоны гэрчилгээ сунгуулах, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн 31 зорчигчийн вагоны гэрчилгээ сунгуулах, Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх үйл ажиллагааны гэрчилгээ шинээр авах “Монголиан транс ложистик” ХХК, “Скай агро ферм” ХХК-ийн материалуудыг үзэж танилцан ажлын хэсгийн 2023 оны 05 дугаар сарын 11, 29-ний өдрийн хуралд тус тус оролцсон. | 100% |
| 6 | Ачаа ба зорчигчийн вагонуудын динамик чанар болон бат бэхийн туршилтын аргууд MNS ГОСТ 33788:2022 стандартыг хэлэлцүүлэхээр ЗТХЯ-руу хүргүүлэх | Албан тоотоор ЗТХЯ-нд хүргүүлэн хариу авсан байна. | 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 189 тоот албан бичгийг Төмөр замын дээд сургуульд стандартын төслийн мэргэжлийн нэр томьёонд хөндлөнгийн дүгнэлт гаргуулах, “Улаанбаатар төмөр зам” ХНН-д 2023 оны 05 дугаар сарын | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | **З.Мөнхтуяа** | | 16-ны өдрийн 216 тоот албан бичгийг “Ачаа ба зорчигчийн вагонуудын динамик чанар болон бат бэхийн туршилтын аргууд MNS ГОСТ 33788:2022 стандарт”-ын төсөлд санал авахаар тус тус хүргүүлж, албан тоотын хариуг цаасаар болон цахимаар хүлээн авсан. | |
| 7 | Дагнасан хэрэглээний зам талбай, обьектын мэдээллийг зам тээврийн салбарын нэгдсэн платформд байршуулах **Д.Бат-Оргил** | Хугацаандаа биелсэн байна. | Зам тээврийн салбарын нэгдсэн платформд дагнасан хэрэглээний зам, талбай объектын гэрчилгээ авсан 161 байгууллагын мэдээлэл оруулсан. | 100% |
| 8 | Гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийн шийдвэрээр дагнасан хэрэглээний зам талбайн техникийн байдлыг газар дээр нь үзэх **Д.Бат-Оргил** | Сардаа биелсэн байна. | Гэрчилгээжүүлэлийн ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу 2023 оны 5-р сард Дархан өртөөний НИК, Өгөөж гурил, Дархан таван нуур, Шунхлай, МТ, Салхит өртөөний Дархан молор эрдэнэ, Шарын гол өртөөний Монмаг, Багахангай өртөөний Хар мөрөн импекс зэрэг компаниудын салбар замуудыг газар дээр нь үзэж, техникийн байдлыг тодруулсан. | 100% |
| 9 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон Дотоод ажлын хүрээнд | Цаг үеийн болон бусад асуудлаар төвийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэн ажилласан байна. | ЗТХ-ийн сайдын 2023 оны "Бүрэн цахимжсан, бүтээмжийг нэмэгдүүлж, хариуцлага үр дүнг тооцох жил" болгон зарлах тухай А/01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 03, 17, 31-нд тус тус шинэчлэн ХШҮМ-д цахимаар буюу /viber/-аар хүлээлгэн өгсөн.<br><br>ГХБАБМХэлтсийн 4 дүгээр сарын төлөвлөгөөний биелэлтийг боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 04-нд ХШҮМ-д цахимаар буюу /viber/-аар хүлээлгэн өгсөн.<br>**Н.Номин**<br><br>Болдтөмөр Ерөө гол ХХК-ны архивын лавлагаа хүссэн 23/170 тоот албан бичгийн дагуу архив шүүж, тус байгууллагын 12 ширхэг зүтгүүрт дугаар олгосон тухай 2020 оны 02-р сарын 07-ны өдрийн 34 тоот албан бичгийг явуулсан.<br><br>ЗТХЯ-ны ПЛАТФОРМ программд шаардлагатай байгаа хөдлөх бүрэлдэхүүний мэдээллийн архивыг шүүж бичсэн. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Мөн "МТЗ" ТӨХК-руу хөдлөх бүрэлдэхүүний мэдээлэл ирүүлэх тухай албан тоотын төсөл боловсруулж илгээсэн.<br><br>Ачааны вагон тооллого явуулах тухай албан тоотын төсөл боловсруулж, 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр ахлах мэргэжилтэн З.Мөнхтуяагийн хамт Улаанбаатар-1 өртөөнд вагон тоолох үйл ажиллагаанд хяналт тавьсан.<br>**Т.Туяа**<br><br>А/20 дугаар тушаалаар байгуулагдсан “Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горим”-ыг боловсруулах ажлын хэсгийн хуралд 2023 оны 05 дугаар сарын 03, 04-ний өдөр оролцсон.<br><br>2023 оны 05 дугаар сарыг Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах сарын аян зохион байгуулах сар болгон зарлаж Монгол Улсад ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүний (зүтгүүр, төмөр замын машин механизм, ачааны вагон, зорчигчийн вагон) насжилтын судалгааг гаргаж, мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэж ажилласан. Мөн “Улаанбаатар төмөр зам” ХНН-тэй хамтран ачааны вагоны нэгдсэн тооллогын ажлыг зохион байгуулж 5 дугаар сарын 25-нд Улаабаатар - 1 өртөөний тооллогын ажилд оролцсон, “МТЗ” ТӨХК, “ТТЗ” ХХК, “МТЛ” ХХК-ийн эзэшлийн зам дээрхи вагон тооллогын мэдээллийг хүлээн авсан.<br>**З.Мөнхтуяа**<br><br>***<u>Мэдээллийн цаг болон бүтээлч ажлын хүрээнд:</u>***<br>2023 оны 05 дугаар сарын 11-ны өдөр Баянгол цэцэрлэгт хүрээлэнд мод тарих арга хэмжээ, 2023 оны 05 дугаар сарын 15-нд УБТЗ нэгдсэн эмнэлэгт ажилтын эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг болон эрт илрүүлгийн үзлэг, 2023 оны 05 дугаар сарын 16-нд “МУ-ын үндсэн хуульд оруулах өөрчлөлт”-ийн төслийн хэлэлцүүлэг, 2023 оны 05 дугаар сарын 04, 09-нд “Жендерийн харилцан тэгш байдал”, “Хөдөлмөрийн | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | аюулгүй байдал эрүүл ахуйн" сургалтанд тус тус хамрагдсан. | |

______o0o______